



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/641

Алтай хот

Сумдын аюулгүйн нөөцөд өвс олгох  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2019 оны А/136 дугаар захирамжаар батлагдсан "Гамшгийн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 4.2 дахь хэсэг, аймгийн Онцгой комиссын 2020 оны 24 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн аюулгүйн нөөцийн саравчинд байгаа 5533 боодол өвсийг нэг бүрийг нь 6500 төгрөгөөр, агуулахад байгаа 7700 боодол өвсийг нэг бүрийг нь 10500 төгрөгөөр тус тус тооцож, сумдын аюулгүйн нөөцөд олгох өвсний хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн аюулгүйн нөөцөд бэлтгэсэн өвсний үнийн зөрүүг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тогтоомжийн дагуу данс бүртгэлд тусгахыг нягтлан бодогч (Н.Наранцэцэг)-д зөвшөөрсүгэй.

3. Хуваарилагдсан өвсийг 2020 оны 11 дүгээр сарын 20-ны дотор татан авч, цаг хүндэрсэн нөхцөлд малчдад худалдан борлуулж, хөрөнгийг аймгийн гамшгийн сангийн дансанд төвлөрүүлэн тайлагнаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Өвсийг зориулалт бусаар зарцуулах, дамлан худалдаалах зөрчил гаргуулахгүй, хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Эрдэнэ-Очир), Цагдаагийн газар (Н.Эрдэнэ-Очир), Мэргэжлийн хяналтын газар (Г.Гантулга), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан)-т даалгасугай.

6. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2020 оны А/599 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ


Ж.ГАНБАТ



C:/My documents/ZAHNH-3A-4 doc

0301001750

Аймгийн Засаг даргын 2020 оны  
11 дугаар сарын 12-ны өдрийн 7/44 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт




АЙМГИЙН АЮУЛГҮЙН НӨӨЦИЙН САРАВЧИНД БАЙГАА  
ӨВСИЙГ СУМДАД ОЛГОХ ХУВААРЬ

№	Сумыннэр	Өвөлжих Малын тоо (толгой)	Өвсний тоо (боодол)	Нэг Бүрийн үнэ (төгрөг)	Ний түнэ (төгрөг)	Агуулахынб айршил
1	Алтай	151367	250	6500	1625000	Аймгийн төвөөс
2	Баян-Уул	271263	250	6500	1625000	
3	Бигэр	128801	250	6500	1625000	
4	Бугат	219750	250	6500	1625000	
5	Дарив	126003	250	6500	1625000	
6	Дэлгэр	191486	250	6500	1625000	
7	Жаргалан	232230	250	6500	1625000	
8	Тайшир	175965	250	6500	1625000	
9	Тонхил	164963	250	6500	1625000	
10	Төгрөг	109754	250	6500	1625000	
11	Халиун	230804	250	6500	1625000	Аймгийн төвөөс
12	Хөхморьт	166910	250	6500	1625000	
13	Цогт	285907	250	6500	1625000	
14	Цээл	239574	250	6500	1625000	
15	Чандмань	150264	250	6500	1625000	
16	Эрдэнэ	251694	250	6500	1625000	
17	Есөнбулаг	141155	250	6500	1625000	
18	Шарга	199258	250	6500	1625000	Шарга сумаас
Дүн			4500	6500	29250000	



Аймгийн Засаг даргын 2020 оны  
 11 дугаар сарын 13-ны өдрийн 4/64 дугаар  
 захирамжийн хоёрдугаар хавсралт



**АЙМГИЙН АЮУЛГҮЙН НӨӨЦИЙН АГУУЛАХАД БАЙГАА  
 ӨВСИЙГ СУМДАД ОЛГОХ ХУВААРЬ**

№	Сумыннэр	Өвөлжих малынтоо (толгой)	Өвсний тоо (боодол)	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	Тайлбар
1	Алтай	151367	250	10500	2625000	Шарга сумаас
2	Баян-Уул	271263	250	10500	2625000	
3	Бугат	219750	250	10500	2625000	
4	Дарив	126003	250	10500	2625000	
5	Тонхил	164963	250	10500	2625000	
6	Төгрөг	109754	250	10500	2625000	
7	Халиун	230804	250	10500	2625000	
8	Хөхморьт	166910	250	10500	2625000	
9	Шарга	199258	250	10500	2625000	
10	Бигэр	128801	250	10500	2625000	Аймгийн төвөөс
11	Дэлгэр	191486	250	10500	2625000	
12	Жаргалан	232230	250	10500	2625000	
13	Тайшир	175965	250	10500	2625000	
14	Цогт	285907	250	10500	2625000	
15	Цээл	239574	250	10500	2625000	
16	Чандмань	150264	250	10500	2625000	
17	Эрдэнэ	251694	250	10500	2625000	
18	Есөнбулаг	141155	250	10500	2625000	
Дүн			4500	10500	47250000	

\_\_оОо\_\_